

ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Э.Энхчимэг

*Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн
гамшиг судлалын, магистрант дэд ахлагч*

Хураангуй: Гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшиг осол тохиолдсон үед хандив, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хандив, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулах, арга замыг тодорхойлох шаардлага бий болж байна.

Судалгааны ажлын явцад хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, цаашид хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтад анхаарах асуудлыг тодорхойлов.

Түлхүүр үг: Хүмүүнлэгийн тусламж, гамшиг, осол, эрх зүйн зохицуулалт, гамшгийн эрсдэлийг бууруулах

Оршил

Дэлхийн цаг уурын дулаарал, газарзүйн байрлалаас шалтгаалан байгалийн аюулт үзэгдэл болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, эрсдэлийн тоо сүүлийн жилүүдэд ихээр нэмэгдэж байна. Үүний улмаас дэлхий нийтэд хүмүүнлэгийн тусламж туслалцаа, түүний зохицуулалтад ихээр анхаарах болжээ.

Манай орны хувьд жилд дунджаар 3000 гаруй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдож гамшгийн улмаас хүний амь нас эрсдэх, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, байгаль орчинд ихээхэн хэмжээний хохирол учирч, нийгмийн хөгжил, эдийн засагт сөргөөр нөлөөлөн ихээхэн гарз хохирол учруулсаар байна.

Монгол Улсын тухайд гамшгаас хамгаалах үйл ажиллагаан дахь дотоодын тусламж, дэмжлэгийн зохицуулалт болон олон улсын хүмүүнлэгийн тусламж, зохицуулалтын талаар тодорхой зохицуулалт байхгүй байсан бөгөөд сүүлийн жилүүдэд Гамшгаас хамгаалах тухай /2017 он/, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /2016 он/ хуулиудын шинэчилсэн найруулгад дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтын талаар тусгай бүлэг, зүйлүүдэд тусгаж оруулсан нь чухал ач холбогдолтой болсон.

Монгол Улсад байгалийн аюулт үзэгдэл болон хүний буруутай үйлдлээс үүдэн гарах гамшгийн тоо жил бүр өсөх хандлагатай байгаа нь цаашид гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаан дахь хандив, хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалт болон зохион байгуулалтыг сайжруулах арга замыг тодорхойлох зүй ёсны шаардлага бий болж байна.

Нэг. Хүмүүнлэгийн тусламжийн талаарх ойлголт

Хүмүүнлэгийн тусламж буюу Humanitarian aid гэдэг нь тусламж хэрэгтэй хүмүүст материаллаг болон дэд бүтцийн туслалцаа үзүүлэхийг хэлнэ. Энэ нь ихэвчлэн төр засаг эсвэл өөр бусад байгууллагууд удаан хугацааны туслалцаа үзүүлэх хүртэл байх түр хугацааны туслалцаа байдаг. Хүмүүнлэгийн Ажлыг Мэргэшүүлэх Европын Их Сургуулиудын сүлжээнээс гаргасан судалгаа нь хүмүүнлэгийн ажлыг “хамгийн түгээмэл үнэ цэнэ болох хүмүүс хоорондын эв санааны нэгдлийг илэрхийлэх суурь бөгөөд ёс суртахуунт үүрэг хариуцлага юм” гэсэн байдаг. Хүмүүнлэгийн тусламжийн үндсэн зорилго бол хүний амь аврах, зовлон гачигдлыг багасгах, мөн хүн чанарыг хүндлэн дээдлэх юм. Иймд түүнийг хөгжлийн тусламжаас салгаж ойлгох хэрэгтэй. Хөгжлийн тусламж бол онцгой байдал, хямрал үүсэх шалтгааны ул суурь болсон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдэд нөлөөлж шийдэхийг оролддог. Гамшиг буюу /disaster/ гэдэг үг нь латин хэлний /did/- муу ба /astro/- од буюу “муу-од” гэсэн үгнээс бүтэх ба энэ нь од эрхэс, төөрөг зурхайн золгүй нөхцөл гэсэн утга санаанаас үүсэлтэй.

Гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламж гэдэг нь гамшгийн аюулд нэрвэгдсэн орон нутгийн хүн амд амьдрах хэрэгсэл болгон үзүүлж байгаа үнэ төлбөргүй тусламжийг хэлнэ.

Хүмүүнлэгийн тусламж нь гадаадын улс орноос гамшиг ослын үед болон хөгжлийн тусламж эсвэл дотоодын зардлаас хүмүүнлэгийн тусламжийн суурь зарчмаар удирдуулсан байдаг.

Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримталдаг.

1. Энэрэнгүй – хаана, хэзээ ч хүний амь насыг хамгаалах, гай зовлонгоос нь хөнгөвчлөх.
2. Шудрага – гамшиг осолд өртсөн хүн амыг дотор нь болон өөр хооронд нь ялгаварлан гадуурхалгүйгээр үндсэн хэрэгцээг нь хангах
3. Төвийг сахих – зөрчилдсөн талуудын аль нэг талыг дэмжихгүй байх
4. Бие даах – улс төр, эдийн засаг, цэргийн эсвэл бусад зорилгоос хүмүүнлэгийн зорилгыг бие даасан байдлыг хангах

Хүмүүнлэгийн тусламжийн байгууллагуудын онцлог нь маш олон төрөл чиглэлийн байгууллагуудаас бүрдэх ба хүмүүнлэгийн тусламжийн

байгууллагууд төрийн болон төрийн бус олон байгууллагуудаас бүрдэх бөгөөд, төрөл бүрийн үзэл баримтлал, урсгалтай, тусламж үзүүлэх тусгайлан чиглэл, шалгууруудтай боловч хүний амь насыг аюулаас гэтэлгэх гэсэн нэгэн зарчмын доор үйл ажиллагаа явуулдаг.

Хоёр. Хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ

Эрх зүйн шинжилгээг Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг түүнийг хэрэгжүүлэхэд хууль болон бусад дүрэм, журам гэсэн гурван чиглэлээр хийлээ. Үүнд:

1. Бодлогын баримт бичиг

а. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д²⁷ 3.1.1.5. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ. гэж ерөнхийлөн тусгасан.

б. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс.

“Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”²⁸ ийн 8.2-т Зэвсэгт хүчин тайван цагт /8.2.4./ гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах; үүрэг хүлээнэ гэж тусгасан.

в. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого.

“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”²⁹-ын үндсэн чиглэлийн 2.3-т “Гамшгийн нэр томъёоны ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 3.3-т “Гамшгийн нэр томъёоны суурь ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох стратегийн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэсний дагуу 3.3.4-т “гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох” гэж тус тус заасан.

2. Монгол Улсын хуулиуд.

²⁷ Монгол Улсын Их хурлын тогтоол, УБ 2010, 48 дугаар тогтоол

²⁸ Монгол Улсын Их хурлын тогтоол, УБ 2015, 85 дугаар тогтоол

²⁹ Монгол Улсын их хурлын тогтоол УБ 2011, 22 дугаар тогтоол

Гамшгаас хамгаалах тухай хууль, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын татварын тухай зэрэг бусад холбогдолтой хуулиудын хүрээнд хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулагдахаар хуульчилсан байна.

а. Гамшгаас хамгаалах тухай хууль “Гамшгаас хамгаалах тухай хууль”³⁰-ийн 4.1.7-т ““гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;”, 4.1.13-т ““гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;”, 8.2-т “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.”, 21.3-т “Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг авч болно.”, 29.1.9-т “Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;”, 32.1.5-т “хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах;”, 38.1-т “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.”, 39.1-т “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Улсын онцгой комисс олон улсын хүмүүнлэгийн тусламж авах саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.”, 39.2-т “Олон Улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид “тусламж үзүүлэгч тал” гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.”, 39.3-т “Тусламж үзүүлэгч тал нь тухайн улсын болон олон улсын байгууллагад бүртгүүлсэн байна.”, 39.4-т “Монголын улаан загалмай нийгэмлэг нь олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль

³⁰ Гамшгаас хамгаалах тухай хууль УБ 2017

тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.”, 40.1-т “Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомж, заавар, удирдамжийн дагуу Улсын онцгой комисс зохицуулж, хяналт тавина.”, 40.2-т “Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.”, 40.3-т “Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 40.4.5-т “хүмүүнлэгийн тусламжтай хамааралгүй асуудлаар мэдээлэл цуглуулах;”, 40.8-т “Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Улсын онцгой комисс Засгийн газарт тайлагнана.”, 41.2-т “Засгийн газар олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагааг зогсоохоор бол энэ тухай шийдвэрийг тусламж үзүүлэгч талд 30 хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.” гэж тус тус тусгасан.

б. Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль

“Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль³¹”-ийн 4.1-т “Хүмүүнлэгийн үйл ажиллагааны чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийн дагуу хөдөлгөөний дүрэм, үндсэн зарчимд нийцүүлэн хөдөлгөөний бүрэлдэхүүн хэсэг болж, Монгол Улсад зөвхөн нэг Улаан загалмай үндэсний нийгэмлэг байгуулагдана.”, 5.1-т “Монголын улаан загалмай нийгэмлэг нь хөдөлгөөний дүрэм, үндсэн зарчим болон Женевийн конвенци, нэмэлт протоколуудыг хэрэгжүүлэх, төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд нэмэлт хүч болж, дэмжлэг үзүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, өөрөө удирдах ёсны зарчимд суурилж үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус, татвараас чөлөөлөгдсөн, үндэсний хүмүүнлэгийн байгууллага мөн.”, 6.2.7-т “олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх, сурталчлах, хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах, олон улсын хүмүүнлэгийн хуулиар хамгаалагдсан Улаан загалмай, Улаан хавирган сар болон бусад таних тэмдгийг хамгаалах талаар төрийн байгууллагатай хамтран ажиллах;”, 10.1-т “Энэ хуулийн 6.2-д заасан чиг үүргийн дагуу Засгийн газар Женевийн конвенцийн хүрээнд дайнд нэрвэгдэгсдэд туслах, зэвсэгт мөргөлдөөн, нийтэд учирсан гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдэгсдэд яаралтай тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх, бэлтгэл сургалт зохион байгуулах, хүмүүнлэгийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээлэл, сурталчилгаа хийхтэй холбогдсон зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж,

³¹ Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль УБ 2016,

эдгээр ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэгтэй жил бүр гэрээ байгуулан санхүүжүүлнэ.” гэж тус тус заасан.

в. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль

“Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль³²”-ийн 6.2-т “Монгол Улс гадны зэвсэгт халдлага, түрэмгийллийг өөрийн зэвсэгт хүчнээр няцааж, ард түмний оролцоотойгоор хамгаалах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллага, бусад улсын тусламжийг авч болно.,” гэж тусгасан.

г. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль³³”-ийн 4.2-т “Гамшгийн хор уршгийг арилгах тодорхой арга хэмжээнд зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаадын болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс Монгол Улсад өгсөн буцалтгүй тусламж, хандивыг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” 8.4-т “Гамшгийн хор уршгийг арилгахад зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын байгууллага, иргэн, хуулийн этгээдээс өгсөн буцалтгүй тусламж, хандивын хөрөнгийг тухайн зориулалтаар нь зарцуулах бөгөөд уг хөрөнгө нь хүрэлцэхгүй бол Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.” гэж тус тус заасан.

д. Гаалийн тухай хууль

“Гаалийн тухай хууль³⁴”-ийн 7.3.3-т “улсыг батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусламж авах;” гэж тусгасан.

е. Гаалийн тариф, гаалийн татварын татварын тухай

“Гаалийн тариф, гаалийн татварын татварын тухай³⁵”-ийн 38 дугаар зүйлийн Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараанд хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;” хэмээн оруулан заасан байна.

3. Дүрэм, журам.

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 416 дугаар тогтоолын хавсралтаар “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг баталж, тус төлөвлөгөөнд хүмүүнлэгийн тусламжийг “Гамшгийн хор уршиг, хохирол үндэсний эдийн засаг, нийгмийн нөөц боломж, чадавхаас давсан тохиолдолд олон улсаас хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг урилгыг засгийн газар гадаад улс, олон улсын байгууллагад гаргана. Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

³² Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль УБ 2016

³³ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль УБ 2006

³⁴ Гаалийн тухай хууль УБ 2008

³⁵ Гаалийн тариф, гаалийн татварын татварын тухай УБ 2008

байгууллагаар дамжуулан хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Засгийн газар уг тусламжийг авах, эсэх талаар шийдвэр гаргана. Хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг нь олон улсын гэрээ, конвенци, Монгол Улсын хууль тогтоомж, эрх ашигт нийцсэн байна. Олон улсын хүмүүнлэгийн дараах төрлийн тусламж авч болно.

- Үнэлгээ зохицуулалтын баг
- Эрэн хайх, аврах баг
- Эм, эмнэлгийн үйлчилгээ
- Хүнс, бараа материал
- Орон байр
- Санхүү
- Бусад хэмээн тусгаж өгсөн.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 271 тогтоолоор “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам” батлагдсан. Энэхүү журмын зорилго нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүн (Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн)-ээс үзүүлэх хандив, тусламж (цаашид “дотоодын хүмүүнлэгийн тусламж” гэх)-аар ирүүлсэн бараа, материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авч байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах харилцааг зохицуулахад оршино. Гамшгийн улмаас учирсан хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн дотоодын хүмүүнлэгийн тусламж хүсэх, уриалга гаргах шийдвэрийг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга гаргана.

Журмаар Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, зарцуулах, тээвэрлэх болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг хадгалах, тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны зардал, тайлан бүртгэл зэрэг асуудлыг тодорхой тусгаж өгсөн.

Дөрөв. Олон Улсын эрх зүйн зохицуулалт

Хүмүүнлэгийн зарчим, үйл ажиллагааны тухай асуудлыг олон улсын хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзэх ёстой.

Олон Улсын Хүмүүнлэгийн Хууль 1949 онд батлагдсан Женевийн конвенц, 1977 онд баталсан нэмэлт протокол зэрэгт хүмүүнлэгийн ажиллагаатай шууд хамаарах 600 орчим заалтууд тусгагдсан бөгөөд эрх зүйн эдгээр баримт бичигт “ард иргэд хүмүүнлэгийн тусламж авах эрхтэй” гэж заасан байдаг.

Олон Улсын Хүний Эрхийн Хууль Энэ хууль нь энхийн цагт ч, зэвсэгт мөргөлдөөн гамшиг, онцгой байдлын үед ч хүний үндсэн бүх эрхийг хамгаалахад чиглэсэн.

Дүрвэгсдийн Хууль 1951 оны дүрвэгсдийн конвенци нь дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийн эрхийг хамгаалахад чиглэсэн.

Дотоодын шилжилт хөдөлгөөний зарчмын удирдамж нь дотооддоо шилжилт хөдөлгөөн хийсэн хүн амыг хамгаалах заавал дагах албагүй зарчим юм.

1864 онд байгуулагдсан Олон Улсын Улаан Загалмайн хороотой (ОУУЗХ) адилаар НҮБ-ын хүүхдийн сан, Хүүхдийг хамгаалах сан болон Оксфам зэрэг хүмүүнлэгийн олон бүлэглэлүүд дайнд нэрвэгдэгсэдийг авран хамгаалах үйл ажиллагааны дунд бий болжээ. Урьдчилан сэргийлэх, урт удаан хугацааны хөгжлийн тусламжийг хэрэгжүүлэх чиглэлээр голлон ажилладаг боловч, тэдгээрийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг мэдээллийн хэрэгслээр илүүтэй мэдээлдэг.

1990 оноос хойш бий болсон хямралын нөхцөл байдлаас болж хүмүүнлэгийн тусламжид найдах болсон нь нэгэнт байгуулагдсан хүмүүнлэгийн байгууллагуудын хариуцлага ачааллыг нэмэгдүүлсэн. НҮБ-ын байгууллагууд, хандивлагч засгийн газрын доорх агентлагууд, ТББ, ОУУЗХ болон зэвсэгт хүчин зэрэг 5 төрлийн хүмүүнлэгийн байгууллагуудын сонирхол, тусламжийн чиглэлийг шинжлэн дүгнэх болно. Хүмүүнлэгийн тусламж, хамгаалалтын олон улсын тогтолцооны тулгуур найман институцүүд байна.

- Хоёр талын байгууллагууд
- Засгийн газар хоорондын байгууллагууд
- Олон улсын ТББ
- Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг
- Гадаад орны үндэсний зэвсэгт хүчин
- Тусламж авах улсын үндэсний Засгийн газар
- Улс төрийн ба цэргийн эсэргүүцлийн /сөрөг хүчин
- Үндэсний ба орон нутгийн ТББ

Дүгнэлт, санал

Гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшиг осол тохиолдсон үед хандив, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хандив, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулах, арга замыг тодорхойлох шаардлага бий болж байна.

Судалгааны ажлын явцад хүмүүнлэгийн тусламжийн эрх зүйн зохицуулалт бий болсон хэдий ч манай улсад жил ирэх тусам олон улсын болон дотоодын хандив, хүмүүнлэгийн тусламжийн хэмжээ нэмэгдэж, гамшигт нэрвэгдсэн малчид, иргэдийн амьдрал ахуй, орон нутгийн эдийн засагт дэмжлэг болж байгаа хэдий ч тухайн хандив, тусламж зорилтот

бүлэгт хүрч үр дүнг үнэлсэн хяналт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах асуудлыг тусгагдаагүй орхигдсон байгаа нь ажиглагдаж байна.

Цаашид гамшгийн эрсдэлийн үнэлгээ, хохирол, хэрэгцээний үнэлгээ болон олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийн санхүүжилтийн нэгдсэн систем бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна.

Дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, НҮБ-аас гаргасан программ 5 W буюу 1.Хэн? 2.Юуг? 3.Хаана? 4.Хэзээ? 5.Хэнд? гэсэн зарчмаар хүмүүнлэгийн тусламж шаардлагатай хот, аймаг, сум, баг, иргэдэд зөв оновчтой зохион байгуулж хуваарилах, хандив, тусламжийг давхцуулан олгохгүй байхад анхаарах, цаашид тухайн орон нутгийн болон төрийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагуудын харилцан уялдаа холбоог улам сайжруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Хамгийн гол нь энэхүү олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламж тусалцааг богино хугацаанд, оновчтой тараан түгээж, зорилтот бүлэгт нь хэрхэн хүргэх вэ гэдэг дээр анхаарах хэрэгтэй байна.

Ашигласан материал

1. (<https://mn.wikipedia.org>)
2. “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2017 он.
3. “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” 2016, 2017он
4. “Монголын Улаан Загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай” хууль 2016 он
5. <http://mercycorps.org.mn>
6. <http://nema.gov.mn/?p=34131/>
7. <http://www.legalinfo.mn/>
8. https://en.wikipedia.org/wiki/Humanitarian_aid/
9. <https://www.adb.org/mn/news/adb-approves-2-million-herders-hit-mongolian-climate-disaster>
10. Humanitarian Charter and Minimum Standards in Humanitarian Response, 2011
11. Humanitarian Country team meeting minutes. 2018.02.22
12. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. 2017 он, Д.Сэржмядаг
13. Гамшгаас хамгаалах талаарх бодлогын баримт бичгүүд. 2016 он
14. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал. 2017 он
15. Гамшгийн нэр томъёоны тайлбар толь. 2012 он
16. Гамшиг Судлалын Хүрээлэн. Судалгааны ажлын эмхэтгэл. 2011-2016 он.

17. Монгол улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл. 2017он
18. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Я.Цэвэл.
19. МУЗН. Үйл ажиллагааны тайлан. 2014 - 2016 он
20. МУЗН. Үйл ажиллагааны тайлан. 2017 он
21. Норвегийн тусламжийн байгууллага. Жилийн тайлан. 2016
22. Статистикийн үндэсний хороо, 1997-2010
23. ХИС, 2013; 2016; 2017
24. ХИС-гийн JPF-2 төслийн тусламжийн дараах судалгааны тайлан, 2016